

## ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Хүн Амын Сургалт, Судалгааны Төв, Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэгтэй хамтран “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 27 дахь дугаараа эрхэм уншигч Та бүхэнд толилуулж байна.

Сэтгүүлийн энэ дугаарын **“Судалгаа”** хэсэгт Монгол улсын хүн амын төрөлтийн цаг хугацааны “темпо” өөрчлөлтийг тайлбарласан судалгааны үр дүнг танилцуулж байна. Япон, БНСУ-ын хүн амын НАСЖИЛТЫН өнөөгийн байдал, цаашдын хандлага, хүн амын НАСЖИЛТЫН шалтгаан, ахмад настны ажил эрхлэлтэнд үзүүлэх нөлөө, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах бодлого зэргийг харьцуулан үр дүнг танилцуулж байна. Түүнчлэн “Хөдөлмөрийн бүтээмжид нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа”-гаар уул уурхайн үйлдвэрийн хөдөлмөрийн бүтээмжид нөлөөлөх хүчин зүйлсийг 8 бүлэг 45 үзүүлэлтийн хүрээнд авч үзэж, тэдгээрийн ач холбогдлыг тодорхойлон танилцуулж байна.

Монголчуудын хамтран амьдрах талаарх ойлголт, хандлагыг гэр бүлийн орчин үеийн хэв маягууд дэлгэрсэн хөгжингүй улс орнуудтай харьцуулан Монголын жишээн дээр тайлбарласан дүн шинжилгээний үр дүнтэй уншигч та танилцах боломжтой.

Монгол хэрэглэгчийн материаллаг хандлагыг илрүүлэх, бизнесийн болон бизнесийн бус байгууллагууд хэрэглэгчид чиглэсэн аливаа үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөх, бий болгох, хүргэхэд мөн тэдний худалдан авах шийдвэр гаргалтын гол учир шалтгааныг ойлгосон “Хэрэглэгчийн зан төлөв дэх материализм”, мөн “Улаанбаатар хотын гар утас хэрэглэгчдийн зан төлөвийн судалгаа”-нуудаас гарсан үр дүн, санал зөвлөмжийг толилуулж байна.

**“Сургалт”** хэсэгт *“Хүн амын ядуурах эмзэг байдлыг үнэлэн тооцох арга зүйн зарим асуудал”* сэдвийн хүрээнд ядуурлын тогтвортой болон тогтворгүй өөрчлөлтийг хэрхэн хэмжих талаар болон ядуурах эмзэг байдлын тооцооны арга зүй, аргачлалыг тодорхой жишээгээр тайлбарласан болно.

**“English”** хэсгээс “Хүүхдийн мөнгө хөтөлбөрт гарах өөрчлөлтийн хүүхдийн ядууралд үзүүлэх нөлөө”-г Өрхийн Нийгэм-Эдийн засгийн судалгааны 2014 оны тоон мэдээллийг ашиглан микросимуляцийн аргаар судалсан шинжилгээний үр дүнг танилцуулж байна. Мөн хөдөөнөөс гадагш шилжих хөдөлгөөн ба алдсан малын тоо хоорондын хамаарлыг шинжлэн дүгнэсэн судалгааны ажлын үр дүнг “Хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөн ба байгалийн гамшигт үзэгдэл Зудын нөлөөллийн хоорондын хамаарал” сэдэвт ажлаар танилцуулж байна.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт толилуулж буй судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар эрхэм уншигч Та шүүмж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэн, санал бодлоо хуваалцаж, манай дараагийн дугаарт өөрийн материалаа ирүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Энэ ялдамд, хүн ам зүй, хүн ам, хөгжлийн асуудлаар судалгаа, эрдэм шинжилгээний ажилд оюун санаагаа зориулан манай сэтгүүлд өөрийн бүтээлээ ирүүлсэн нийт эрдэмтэн, судлаачид болон уг сэтгүүлийн энэ дугаарыг бэлтгэн хэвлэхэд санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Монгол Улсын Их Сургуульд сэтгүүлийн редакцийн хамт олон гүн талархлаа илэрхийлж байна.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

**РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ**